

**“Эрдэнэс-Тавантолгой ХК”**

Огноо: .....

**ЭМ ТАРИА, ОРООХ БООХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: Эм тариа, ороох боох материал нийлүүлэгчийг сонгох**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар: ЭТТ/201901257**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн буюу 2018 оны баталгаажсан санхүүгийн тайлангийн хуулбар хувь</li> <li>2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>3. Сүүлийн 2 жилийн 2017, 2018 оны аль нэг жилд ижил төстэй 2-ээс доошгүй бараа нийлүүлсэн гэрээг нотариатаар баталгаажуулан гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх.</li> <li>4. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/</li> <li>5. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</li> <li>6. Санал болгож буй барааны танилцуулга ирүүлэх/Тендерийн баримт бичигт заагдсан техникийн үзүүлэлттэй харьцуулсан үзүүлэлт/</li> <li>7. Шүүхийн төрөлжсөн архив тодорхойлолт ирүүлэх /тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр хугацаатай байна/</li> <li>8. Барааны гарал үүслийн гэрчилгээ, нотлох баримтыг ирүүлэх</li> <li>9. Тендерт шалгарсан тохиолдолд санал болгосон бараа техникийн тодорхойлолтын дагуу бараа материал нийлүүлэх гэсэн албан бичиг ирүүлнэ үү.</li> <li>10. МУ-ын эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл, нотариатаар баталгаажуулан ирүүлэх</li> <li>11. Эм эмнэлгийн хэрэгсэл нь Орос, ХБНГУ, БНСУ, Энэтхэг улс, Олон улсын фармакопейн стандартуудыг хангасан нотлох бичиг баримт ирүүлнэ.</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв</b>  <b>Утас: 75055555 (504), факс: 70118464</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>5 давхар 503 тоот</b>  Огноо: <b>2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>5 давхар 503 тоот</b>  Огноо: <b>2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 40 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

- Эм, эмнэлгийн хэрэгсэл нь үндэсний зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад орсон, эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, савлагаа, шошгоны стандарт нь үндэсний стандарт эсвэл эм үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хяналтын дүрэм (СМР) –ийг бүрэн хангасан байна.
- Барааны тодорхойлолтонд эмийн хэлбэр/шахмал, тарилгын уусмал болон нунтаг, тосон түрхлэг гэх мэт/ болон найрлага, тун хэмжээ /мг, процент/-г заана.
- Эм, эмнэлгийн хэрэгслээс гадна савлагааны материал нь (шил, хуванцар сав гэх мэт) Монгол улсын цаг агаарын нөхцөлд тохирсон стандартыг хангасан байна. Бүх савлагаа нь зохих журмын дагуу дахин савлах боломжгүйгээр битүүмжлэгдсэн байна.
- Хадгалалтын тусгай горим шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн тогтвортой байдлыг хангахын тулд шошго болон сав, баглаа боодолд үүнийг тусгайлан зааж тээвэрлэлтийн явцад мөрдөнө.
- Бүх эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэсэн огноо заагдсан байна. Захиалагчийн агуулахад нийлүүлэгдэх үед эм, эмнэлгийн хэрэгслийг цаашид хэрэглэж болох хугацаа нь тухайн бүтээгдэхүүний хүчинтэй байх хугацааны зургааны тав (5/6)- аас доошгүй байна.

№	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР / сэлбэг, барааны дугаар/	Хэмжих нэгж / Тоо хэмжээ		ЗОРИУЛАЛТ	ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ	Үлдэ гдэл /тоо ширхэ г/
1	Ибупрофен 600мг № 100	уп	70	Өвчин намдаах, үрэвслийн эсрэг эм	<ul style="list-style-type: none"> <li>• Эм тарианы дуусах хугацаа нь урт байх шаардлагатай.</li> <li>• Европын улс орнуудад үйлдвэрлэгдсэн эм байх.</li> <li>• Эмийн чанарын баталгаажилт лабораториор баталгаажсан байна.</li> </ul>	
2	Трамадол 100мг-2мл №20	уп	10	Хүчтэй өвдөлт намдаах тариа		
3	Диклоденк 100мг №100	уп	90	Үрэвслийн эсрэг стероид бус бэлдмэл		
4	Диклоденк 75мг 3мл №5	кор	15	Үрэвслийн эсрэг өвчин намдаах стероид бус бэлдмэл		
5	Макрофен 400 мг №16	уп	100	Үрэвслийн эсрэг антибиотик		
6	Эритромицин 400мг №10	уп	80	Үрэвслийн эсрэг антибиотик		
7	Хиконцил 500 мг №16 KRKA	уп	100	Үрэвслийн эсрэг антибиотик		
8	Ципрофлоксаци н 500мг №20	кор	80	Үрэвслийн эсрэг антибиотик		
9	Цефазолин 1,0гр	фл	50	Үрэвслийн эсрэг тариа		
10	Цефатаксим	фл	50	Үрэвслийн эсрэг тариа		
11	Азитромицин 500мг №3	уп	50	Үрэвслийн эсрэг антибиотик		

12	Доктор Айболит №10	уп	300	Нийлмэл найрлагатай ханиалга дарах эм		
13	Кол Колс №10	уп	300	Нийлмэл найрлагатай ханиалга дарах эм		
14	Лоратадин №20	уп	50	Антигистамин		
15	Ризин №10	уп	50	Антигистамин		
16	Гриппоблок /adult/ №10	уп	80	Нийлмэл найрлагатай ханиалга дарах эм		
17	Трахисан №20	кор	200	Хоолойн өвдөлт намдаах эм		
18	Либексин 100мг №20 /Sanofi/	кор	15	Ханиалга дарах эм		
19	Тамедин 0,7%-100 мл	фл	80	Ам зайлах уусмал		
20	Тамедин 2,5%-300 мл	фл	20	Шарх цэвэрлэх уусмал		
21	Кордиамин 250мг/1 мл №10	кор	1	Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих тариа		
22	Кардиомагнил 75 мг №100	фл	3	Антикоагулянт		
23	Ко-Валсартан 160/25 №30	кор	2	Артерын даралт бууруулах		
24	Нитроглицерин 0,5мг №40	уп	4	Зүрхний бахын өвдөлт намдаах эм		
25	Панангин 10мл №5	кор	10	Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих тариа	<ul style="list-style-type: none"> <li>• Эм тарианы дуусах хугацаа нь урт байх шаардлагатай.</li> <li>• Европын улс орнуудад үйлдвэрлэгдсэн эм байх.</li> <li>• Эмийн чанарын баталгаажилт лабораториор баталгаажсан байна.</li> </ul>	
26	Панангин №50	кор	8	Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих эм		
27	Кокорбоксилаза 0,05г №5	кор	5	Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих тариа		
28	Дигоксин 0,25мг/1мл №10	кор	1	Зүрхний гликозид		
29	Атропин сульфат 0,1%-1мл №10	кор	1	М холинолитик		
30	Энап НЛ 10мг+12,5мг №20	кор	5	Даралт бууруулах нийлмэл найрлагатай эм		
31	Нефрис №100	уп	10	Бөөр, шээсний замын үрэвсэл намдаах эм		
32	Кальци глюконат 10%-10 мл №10	кор	10	Булчин агшаах тариа		

33	Релиф ультра №12	уп	5	Үрэвслийн эсрэг, цус тогтоох лаа	
34	Апрокант 10000КИУ №5	уп	3	Уураг задалдаг ферментийн идэвхийг бууруулах тариа	
35	Вольтарен 50 мг тосон түрхлэг	тюб	10	Үе мөчний өвдөлт намдаах тосон түрхлэг	
36	Нexcare 18мл спрэй	фл	10	Үе мөчний гэмтлийн үед шүршиж хэрэглэнэ	
37	Ацикловир 5%-5 мл	тюб	25	Вирусын халдварын эсрэг хэрэглэх тосон түрхлэг	
38	Нэг удаагийн зүү 23G	хай рцаг	5	Тарилга хийхэд хэрэглэнэ.	
39	Нэг удаагийн зүү 22 G	хай рцаг	5	Тарилга хийхэд хэрэглэнэ.	
40	Хуруу лент №30	кор	100	Шарханд наана.	
41	Панфеникол	фл	10	Шархны цацлага	
42	Аскорбины хүчил 5%-2 мл №10	уп	10	Антиоксидант	
43	Дексаметазон 4мг-1мл №25	кор	10	Дааврын гаралтай үрэвслийн эсрэг тариа	
44	Натри хлорид 0,9%-2 мл №50	кор	5	Тариа найруулахад хэрэглэнэ.	
45	Натри хлорид 0,9%-100 мл	фл	100	Тариа найруулахад хэрэглэнэ.	
46	Лидокайн 2%-2мл №10	кор	20	Хэсгийн мэдээ алдуулалтанд хэрэглэнэ.	
47	Реамберин 1,5%-400 мл	фл	20	Хүчилтөрөгчийн дутмагшлын эсрэг тариа	
48	Долоогоны ханд 20 мл	фл	25	Зүрхний булчингийн сэрэмтгий чанарыг бууруулна.	<ul style="list-style-type: none"> <li>• Эм тарианы дуусах хугацаа нь урт байх шаардлагатай.</li> <li>• Европын улс орнуудад үйлдвэрлэгдсэн эм байх.</li> <li>• Эмийн чанарын баталгаажилт</li> </ul>
49	Чих цэвэрлэгч №100	кор	80	Эмнэлгийн хэрэглээнд	
50	Үзлэгийн бээлий S, M	хай рцаг	30	Эмнэлгийн хэрэглээнд	
51	Нэг удаагийн маск	боо дол	8	Эмнэлгийн хэрэглээнд	
52	Хэл дарагч №100	боо дол	5	Эмнэлгийн хэрэглээнд	

53	Лоперамид №10	кор	70	Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг бууруулах эм	лабораториор баталгаажсан байна.		
54	Хлорамфеникол 500 мг №10	кор	10	Ходоод гэдэсний замын үрэвслийн эсрэг эм			
55	Метронидазол 500 мг №20	уп	50	Ходоод гэдэсний замын үрэвслийн эсрэг эм			
56	Омепразол 20 мг №20	кор	80	Ходоодны хүчил бууруулах эм			
57	Рингер лактат 200 мл	фл	50	Хордлого тайлах, шингэх нөхөх			
58	Гидровит ORS №10	пакет	40	Шингэн сэлбэх давсны уусмал			
59	Уголь 250 мг №10	уп	150	Шингээх эм			
60	Сенна №30	кор	2	Туулгах эм			
61	Натри хлорид 200 мл	фл	50	Хордлого тайлах, шингэн нөхөх, нүд угаах			
62	Амино комплекс 250 мл	фл	20	Судсаар тэжээх			
63	Пантоген 250 мл	фл	20	Хордлого тайлах			
64	Бамбайн ханд 20 мл	фл	40	Тайвшруулах			
65	Эрвалкор 20 мл	фл	20	Зүрхний хэм алдалтын эсрэг хэрэглэнэ.			
66	Хиймэл нулимс	фл	100	Нүд хуурайших үед хэрэглэнэ.			
67	Тобродекс 5 мл	фл	30	Нүдний өвчний үед үрэвслийн эсрэг			
68	Отипакс	фл	10	Чихний үрэвслийн үед хэрэглэнэ.			
69	Спирт 76% -5л	фл	3	Ариутгал, тарилга хийхэд хэрэглэнэ.			
70	Маннитол 10%-250 мл	фл	7	Тархины хаван хөөх			
71	Глюкоз 5%-250 мл	фл	10	Бодисын солилцоог сайжруулах			
72	Глюкоз 40%-10 мл	фл	5	Бодисын солилцоог сайжруулах			
73	Омарон 400/25 мг №60	кор	10	Тархины цусан хангамжийг сайжруулах эм.		• Эм тарианы дуусах хугацаа нь урт байх шаардлагатай.	
74	Вишневский мазь 30 г	ширхэг	10	Шарханд түрхэж хэрэглэнэ.			



75	Синтомицин линимент 10%- 25г	шир хэг	5	Шарханд түрхэж хэрэглэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Европын улс орнуудад үйлдвэрлэгдсэн эм байх.</li> <li>• Эмийн чанарын баталгаажилт лабораториор баталгаажсан байна.</li> </ul>	
76	Ариутгасан бинт	шир хэг	100	Эмнэлгийн хэрэглээнд		
77	Ариун бээлий M S size	хай рцаг	4	Эмчийн гардан үйлдэлд хэрэглэнэ.		
78	Ариутгасан хөвөн	шир хэг	50	Эмнэлгийн хэрэглээнд		
79	Ариун наалт 5*7,5	шир хэг	100	Шарханд нааж хэрэглэнэ.		
80	Ариун наалт 5*9	шир хэг	100	Шарханд нааж хэрэглэнэ.		
81	Эуфиллин 2,4%- 5 мл №10	кор	1	Гуурсан хоолойн агчил тавиулах тариа		
82	Церукал 2мл №10	кор	1	Бөөлжилтийн эсрэг тариа		
83	Отривин спрей 0,1%-10 мл	фл	50	Хамрын хөндийн хаван бууруулах		
84	Називин 0,05%- 10 мл	фл	50	Хамрын хөндийн хаван бууруулах		
85	Дуслын систем	боо дол	13	Тарилгад хэрэглэнэ.		
86	Уян бинт /нарийн/	шир хэг	40	Бэртэл, гэмтлийн үед хэрэглэнэ.		
87	Уян бинт /бүдүүн/	шир хэг	40	Бэртэл, гэмтлийн үед хэрэглэнэ.		
88	Нэг удаагийн тариур 3 мл	хай рцаг	5	Тарилгад хэрэглэнэ.		
89	Нэг удаагийн тариур 5 мл	хай рцаг	5	Тарилгад хэрэглэнэ.		
90	Нэг удаагийн тариур 10 мл	хай рцаг	5	Тарилгад хэрэглэнэ.		
91	Нэг удаагийн тариур 20 мл	хай рцаг	5	Тарилгад хэрэглэнэ.		
92	Калийн холимог 100 мл	фл	10	Гипокалиемийн үед хэрэглэнэ.		
93	Энап 1,25 мг/мл №5	кор	3	Даралт бууруулах тариа		
94	Димедрол 1мл №10	кор	10	Антигистамин тариа		
95	Анальгин 500мг- 2мл №10	кор	10	Өвчин намдаах тариа		
96	Энап 5мг №20	кор	10	Даралт бууруулах эм		
97	Диротон 10 мг №20	кор	10	Даралт бууруулах эм		
98	Гентамицин 2 мл №10	кор	10	Үрэвслийн эсрэг тариа		

99	Комбидерм 15г	фл	15	Арьсан дээрх тууралтын үед хэрэглэнэ.		
100	Бепантен крем	тюб	15	Арьсан дээрх тууралтын үед хэрэглэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Эм тарианы дуусах хугацаа нь урт байх шаардлагатай.</li> <li>• Европын улс орнуудад үйлдвэрлэгдсэн эм байх.</li> <li>• Эмийн чанарын баталгаажилт лабораториор баталгаажсан байна.</li> </ul>	
101	Аюулгүйн хайрцаг	шир хэг	25	Эмнэлгийн хэрэглээнд		
102	Панзенорм 10000ЕД №30	кор	80	Нойр бучирхайн үйл ажиллагааны дутагдлын үед хэрэглэнэ.		
103	ЕААК 40%-10 мл №10	кор	1	Цус тогтоох		
105	ЕААК 5%-100 мл	кор	5	Цус тогтоох		
106	Тетрациклины мазь 3%, 15г	фл	5	Үрэвслийн эсрэг тосон түрхлэг		
107	Беневрон 4мл №10	кор	10	Антиоксидант		
108	Витамин В12 1мл №10	кор	10	Антиоксидант		
109	Экватор 20/10мг №20	уп	5	Титэм судасны дутагдал, даралт бууруулах		
110	Glikolak 37mm ½ нэг удаагийн оёдлын зүү утас	шир хэг	20	Хуйхны оёдол тавихад хэрэглэнэ.		
111	Нарийн пластырь	шир хэг	20	Эмнэлгийн хэрэглээнд		
112	Шархны лент	шир хэг	10	Эмнэлгийн хэрэглээнд		
113	Ус төрөгчийн хэт исэл 3%-500 мл	фл	5	Шарх цэвэрлэхэд хэрэглэнэ.		
114	Шээсний тест №25	хайрцаг	1	Эмчийн оношлогоонд хэрэглэнэ.		
115	Преднизолон 30мг/1 мл №3	кор	2	Цус тогтоох		

## 2. . Чанар, стандарт:

- Монгол Улсын Хуулийн 2010 оны 5 дугаар сарын 27- ны өдрийн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай шинэчилсэн найруулгад заасан дагуу.
- Санхүү, эдийн засгийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01/06 тоот тушаалын хавсралтын дагуу уялдан эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлдэг байх.
- Эрүүл мэнд спортын сайдын тушаал 2016.03.22-ны Дугаар А85, Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.5 дахь заалтыг үндэслэх.



Тав. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа *6 сар* байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт,
  - 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100%** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0.5%**
- Алдангийн нийт дүн: **Гүйцэтгээгүй үнийн дүнгийн 50% хүртэл**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.



Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.